

“ШИВЭЭ-ОВОО” ХК 2019 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь тухайн төслийн байгаль орчинд учруулж буй гол нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж, тухайн жилд түүнд шаардагдах хөрөнгө зардлыг баталгаатай байлгах үндэслэл болно. Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор аймгийн байгаль орчны газарт хүргүүлнэ.

2019 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээж авсан аймгийн Байгаль орчны газар түүний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, ажилуулан дүгнэлтийг 12 дугаар сарын 1-ний дотор гаргуулна. Тус ажлын хэсэгт аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, Байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын газар, Сав газрын захиргаа, сумын ЗДТГ-ын төлөөлөл, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч, Газрын даамал орно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг ажлын хэсгийн гишүүд газар дээр нь очиж шалган 0-100% хүртэл оноогоор дүгнэх ба 80%-иас дээш байвал биелэлтийг хангалттай гэж үзнэ.

Ашигт малтмалын орд ашиглаж буй төсөл хэрэгжүүлэгч уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн тухайн жилийн мэдээг БОХ-3 маягтын дагуу гаргаж тухайн сум, дүүргийн ЗДТГ-т жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор хүргүүлэх ба байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заавал хавсаргана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн, биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батална.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүрийн 03 -р сарын 25-ны дотор БОНХЯаманд боловсруулж хүргүүлэн баталгаажуулна

2019 онд техник, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа буурсан, хөрс хуулалтын хоцрогдол нэмэгдэж байгаа нөхцөл байдлаас хамааруулж шаардлагатай техникүүдийн хөрөнгө оруулалтаар хөрс хуулалтын ажлыг нэмэгдүүлэн гүйцэтгэхээр уулын ажлын төлөвлөгөөг боловсруулсан.

Хөрс хуулалтын ажил нэмэгдэж уурхайн гүн 100 гаруй метрт хүрч мөн хөрсний хоцрогдол үүссэн байдлыг бууруулах дотоод овоолгийн ачааллыг удирдах арга хэмжээний хүрээнд автотээвэр хосолсон хөрсний конвейерийн шаардлагыг тодорхойлох 2020 онд ашиглалтанд оруулахаар тусгах бэлтгэл ажлыг гүйцэтгэх зэргээр боловсруулав.

Технологи ажиллагааны процесс

Шивээ-Овоо ХК-ны технологийн үйл ажиллагаа нь дараах шатлалаар явагдана.

1. Уурхайн талбайн хатаалт /ус шүүрүүлэлт/

Уурхайн гүний усыг карьерийн талбайгаас шахаж зайлуулна. Зайлуулж буй усныхаа ихэнх хэсгийг хаялагын нуурыг сэргээх, карьерийн зам талбайн тоосжилтыг дарах, нөхөн сэргээлтийн мод, бут, сөөг тарих г.мэт байгаль орчноо хамгаалах ажилд хэрэглэж байна.

2. Шимт хөрс хуулалт

Шимт болон шимэрхэг хөрсний зузааныг тодорхойлж түүнийг дугуйт ачигч, түрэгч, бульдозероор хуулж экскаватораар ачиж нөхөн сэргээлтийн талбайд ашиглах ба барилга байгууламж мөн эвдэрсэн газар нөхөн сэргээх зэрэгт ашиглагдана.

3. Өрөмдлөгийн ажил

Карьерийн доголдуудыг үечилэн өрөмдлөгийн талбайг тэгш сайтар засаж бэлтгэнэ чулуулгийн хатуулгаас хамаарч параметрийг тодорхойлж өрөмдлөгийн ажил гүйцэтгэнэ.

4. Тэсэлгээний ажил

Өрөмдөгдсөн талбайд ажиллах техник, тоног төхөөрөмжөөс хамааран тэсрэх бодис тээвэрлэх, цэнэглэх, тэслэх ажлуудыг гүйцэтгэж чулуулгийг сийрэгжүүлнэ.

5. Ухаж ачих ажил

5.1 Нүүрс олборлолт

Уурхайн карьерийн бэлтгэгдсэн ам траншейн зам талбайгаар нүүрсийг экскаватор автосамосвалын хослол, автосамосвал конвейерийн хослолоор ухаж ачиж ТДХ-ийн вагон ачилтын бутлуур болон агуулах руу тээвэрлэнэ.

5.2 Тээвэргүй

Ашиглагдсан орон зайд дотоод нөхөн дүүргэлтийг тээвэргүйгээр драглайн төрлийн экскаватораар гүйцэтгэх ба нүүрсний хил заагийг гаргана.

5.3 Тээвэртэй

Уурхайн карьерийн гадаад болон дотоод орон зайд экскаватор автосамосвалын хослолоор ухаж ачиж сайтар бэлтгэгдсэн ам траншейгаар овоолго руу чулуулгийг тээвэрлэнэ.

6. Борлуулалт

Авто болон төмөр замаар нүүрсийг дулааны 4-р цахилгаан станцад болон бусад хэрэглэгчдэд борлуулна.

7. Нөхөн сэргээлт

7.1 Техникийн нөхөн сэргээлт

7.1.1 Техникийн нөхөн сэргээлтийг гүйцэтгэхдээ аюулгүй байдлын шаардлагыг ханган ажиллана. Үүнд:

7.1.1.1 Нурах эрсдэлтэй, суулт үүссэн нүх болон уурхайн доторх хонгилын тоог гаргана. Нурах эрсдэл хэт өндөр байгаа тохиолдолд энэхүү аргачлалын дагуу нөхөн сэргээлт хийхгүй байх.

7.1.1.2 Талбайд үүссэн овон товон гадаргууг тэгшлэх, налуу гадаргууг орчных нь гадаргуугийн хэлбэр төрхтэй ойртуулан хэлбэршүүлэх, тогтворжуулах арга хэмжээ авах.

7.1.1.3 Усны урсгалын нөлөөгөөр элэгдэлд өртөж болзошгүй бол усны элэгдлээс сэргийлэх, хөрсний тогтвортой байдлыг хангах зорилгоор олборлолтоос үүссэн овоолго материал, чулуулгаар дүүргэлт хийх. (Хэлбэржүүлэхдээ налуу зохих өнцгөөс хэтрүүлэхгүй байх).

7.1.1.4 Уурхайн бага оврын техник ашиглан, овоолго, хаягдал чулуулаг, хана мөргөцгийн оройг намсгаж, хэлбэршүүлэх, дүүргэлт хийсэн талбайг тэгшлэх.

7.1.1.5 Уурхайн тоног төхөөрөмж, машин техник ашигласны улмаас дагтаршиж, нягтарсан хөрсийг сийрэгжүүлэх.

7.1.1.6 Техникийн нөхөн сэргээлт хийсэн газрын гадаргууг эхлээд хөрсөн доорх шимтлэг шороогоор дараа нь хадгалсан шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлт хийхэд тохиромжтой байх нөхцөлөөр хангах.

7.1.2 Техникийн нөхөн сэргээлтийн хамгийн сүүлчийн үе шат

7.1.2.1 Дээр дурьдсан бүх үе шатны ажлыг хийж дууссан гадаргууг шимт хөрсөөр бүрэх шаардлагатай үе шат юм. Энэ тохиолдолд тусад нь овоолон хадгалсан шимт хөрснөөс ачиж тээвэрлэн гадаргуу дээрээ тарааж байршуулна.

7.1.2.2 Техникийн нөхөн сэргээлтэнд шимт хөрсийг хуулж хадгалах, эвдэрсэн газар, овоолго зам талбайг хэлбэршүүлэх, шимт хөрсөөр хучих, биологийн нөхөн сэргээлтийн үед үр суулгац, бордоо худалдан авах, усалгааны систем бий болгох, арчилж тордох, хашаа хамгаалалт барихад шаардагдах бүх ажлын явцад гарах нийт зардал орно.

7.2 Биологийн нөхөн сэргээлт

Эвдрэлд орсон газрыг унаган төрхөөр хэлбэршүүлж бэлтгэсэн талбайд үржил шимт олон наст ургамал зэргийг тарьж ургуулах. Биологийн нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах зардлуудыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-г заасныг үндэслэн,

Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2017 оны 08 сарын 17-ны өдрийн А/226, А/182 дугаар тушаалын хавсралт болох нөхөн сэргээлт хийгдэх ажлын үнэлгээ тооцох аргачлал"-ын дагуу боловсруулна.

ТЕХНОЛОГИ АЖИЛЛАГААНЫ ПРОЦЕСС



2019 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЛААР

2019 онд 2000.0 мян.тн нүүрс олборлон борлуулж, нийт хөрс хуулалт 8752.2 мян.м³ үүнээс тээвэргүйгээр 2202.2 мян.м³, тээвэртэйгээр 6550.0 мян.м³, 2730.6 мян.м³ хөрс дахин шидэлт, 140.0 мян.м³ автын инженер ажил, 330.0 мян.м³ автын бус инженер ажлуудыг хайгуулын IX-XII шугамын хооронд гүйцэтгэхээр төлөвлөгдсөн.

Тээвэргүй хөрс хуулалтанд:

Тээвэргүй хөрс хуулалтанд ЭШ-25/90, ЭШ-11/70 алхагч экскаватораар нүүрс нээх ажил хийнэ. ЭШ-25/90 Алхагч экскаватор нь хайгуулын IX-XI шугамын хооронд дунджаар 680 м фронтын урттай 60-75 м орлын өргөнтэй, 27-36 м доголын өндөртэйгээр 1479.2 мян.м³ хөрс хуулж 2039.0 мян.м³ Дахин шидэлт хийж нийт 3518.2 мян.м³ уулын цулын ажил гүйцэтгэнэ.

ЭШ-11/70 Алхагч экскаватор нь хайгуулын XI-XII шугамын хооронд дунджаар 470 м фронтын урттай 50-55 м орлын өргөнтэй, 28-34 м доголын өндөртэйгээр 723.0 мян.м³ хөрс хуулж 691.6 мян.м³ дахин шидэлт хийж нийт 1414.6 мян.м³ уулын цулын ажил гүйцэтгэнэ.

Нийт тээвэргүйгээр 2202.2 мян.м³ хөрс хуулж, дахин шидэлтээр 2730.6 мян.м³ уулын ажил гүйцэтгэнэ.

Тээвэртэй хөрс хуулалт:

Тээвэртэйгээр 6550.0 мян.м³ хөрс хуулахаар төлөвлөв. Үүнээс: үндсэн завсрын хөрс 1085.0 мян.м³, шимт хөрс 40.0 мян.м³-ыг тус тус хуулна. Хөрс хуулалтанд ЭКГ5А, ЭКГ10И шууд утгуурт цахилгаан экскаватор Komatsu HD405-6 /40тн/, САТ-773 /55тн/, Белаз7555В /55тн/, Белаз75137 /130тн/ автосамосвалуудын хослолоор ажиллана.

Хүснэгт №3

Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө, мян.м ³	Хайгуулын шугам	Ажиллах түвшин, м	Талын дундаж зай, км
Шимт хөрс	40.0	IX-XIII		
Автын 1-р суулт	969.1	IX-XIII	1207.0	2.0
Автын 2-р суулт	1365.7	IX-XIII	1197.5	2.0
Автын 3-р суулт	1393.9	IX-XIII	1188.0	2.0
Автын 4-р суулт	720.4	IX-XIII	1178.5	3.0
Автын 5-р суулт	1015.9	IX-XIII	1169.0	2.9
Дүн 1	5465.0			2.4

Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө, мян.м ³	Хайгуулын шугам	Ажиллах түвшин, м	Талын дундаж зай, км
Завсрын хөрс	1085.0	IX-XIII	1113-1140	2.6
Дүн 2	1085.0			2.6
Хөрс дүн	6590.0	IX-XIII	1113-1219	2.5

Нийт гадаад овоолгод дунджаар үндсэн хөрсөнд 2,4 км, завсрын хөрсөнд 2,6 км уурхайн дунджаар тээвэртэй хөрсөнд 2,5 км байна.

Шимт хөрс

2019 онд зүүн хойд чиглэлд үүсэх гадаад овоолгийн талбай болон зүүн жигүүрийн ахилтын талбайгаас нийт 40.0 мян.м³ шимт хөрсийг хуулж ашиглалтын 2-р амнаас 3-р амны хооронд дотоод овоолго мөн 1-р амны дотоод овоолгийн хэсэгт техникийн нөхөн сэргээлт хийхэд зарцуулахаар төлөвлөв.

Инженер ажил

Автотээвэртэйгээр түрүүлэгч буюу далангийн 90.0 мян.м³, төв мост хийх 30.0 мян.м³ бусад 20.0 мян.м³ нийт 140.0 мян.м³, автын бусаар дотоод овоолгийн гурвалжингийн нүүрсийг зааглах, дотоод олборлолтын зам траншей суулгах, бутлуурт нүүрс шигших зэрэг 330.0 мян.м³ нийт 470.0 мян.м³ инженер ажил хийж гүйцэтгэнэ.




Нүүрс олборлолт

Ашиглалтын 2-р ам хайгуулын 9-11-р шугам, тооцооны 85-119-р огтлол хооронд 013311А тусгай зөвшөөрлийн 1-р давхаргын 4В, 12В, 13В, 2-р давхаргын 8В, 26В, 27В блокын талбайгаас нийт 1369.9 мян.тн нүүрс олборлоно. Үүнээс 1-р давхаргын 917.8 мян.тн, 2-р давхаргын 451.8 мян.тн нүүрс, Ашиглалтын 3-р ам хайгуулын 11-13-р шугам, тооцооны 114-135-р огтлол хооронд 013311А тусгай зөвшөөрлийн 1-р давхаргын 12В, 34С, 2-р давхаргын 27В, 31С блокын талбайгаас нийт 630.4 мян.тн, 1-р давхарга 512.6 мян.тн, 2-р давхарга 117.8 мян.тн нүүрс олборлон борлуулхаар төлөвлөж ажиллаж байна.

Нийт 1-р давхаргын нүүрс 1430.4 мян.тн

2-р давхаргын нүүрс 569.6 мян.тн

2019 онд хатаах үйлдвэрийн конвейерийн систем складын үлдэгдэлтэйгээ 700.0 мян.тн, ТДХ-ийн агуулах болон вагон ачилтаар 1300.0 мян.тн нүүрс тээвэрлэнэ. Ашиглалтын 2-р амнаас талын дундаж зай 3.2 км-т 1090.0 мян.тн, ашиглалтын 3-р амнаас хатаах үйлдвэрийн конвейер хүртэл талын дундаж зай 1.7 км 700.0 мян.тн, ТДХ-ийн агуулах хүртэл талын дундаж зай 4.2 км-т 210.0 мян.тн нийт 2.0 сая.тн нүүрсийг талын дундаж зай дунджаар 2,9 км байна.



байна. Ургамлын бүрхэвч устаж үгүй болох нөхцөлд олборлолтын ажил дуоһнаагаа аадаа баа
 íòààèéí áýè÷ýýðèéí í°ò°í ñýðáýýð àñóóààè ÷òèèààð òààèàààíà.

Àìüðíü àéìààð ¿¿¿ýõ í°è°è°è

Шивээ Овоогийн уурхайд ашиглалт явуулах нь амьтны аймаг, ялангуяа хөхтний байршил,
 òàðòàò, òíí òíèàíéà øóóà í°è°è°è°. Õ¿í, ìàøèí òàðíèèèéí ò°è ò°à°èà°°í, àóó ÷èìýý, áýðýè
 сүдэүүн îð÷èí òíéðíü 2-3 км хүртэлх зайд байгаа зарим том хөхтөн дайжиж зайлна. Уурхайн үйл
 ажиллагаанаас амьтны аймагт шууд үзүүлэх нөлөөлөл харьцангуй бага боловч амьтан устах
 ààèæèð, îð÷èí òíðèè¿éòýð сүдэү ñ°ð°à í°è°è°è°ñ ¿¿áýí àìüðíü àéìààð ààì í°è°è° àèü íýà
 õýìæýáýýð çàèèø¿è ààðàà. Æèæèà ìýðá÷ýýð òííèèíàíà ò°òò°í, øóáóóà òýæýýýý ààààè
 çóðààñ íòààèéí îð÷ííñ òíèèíí.

Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл

Хүснэгт №4

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдаг	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Байгаль орчны бүрдэл хэсгүүдийн өөрчлөлт										
Гүний усны нөөц хомсдох			X							
Газрын доорхи усны чанарын өөрчлөлт			X							
Ургамлын бүтцийн өөрчлөлт	X		X		X	X			X	
Хөрсний элэгдэл, эвдрэл	X				X		X	X		
Геологийн тогтоцын өөрчлөлт	X				X		X	X		
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт	X			X		X				X
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			X							X

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагддаг	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Байгалийн нөөцөд үзүүлэх нөлөөлөл										
Газрын хэвлийн нөөц баялаг	х				х		х		х	
Бэлчээрийн, тэжээлийн байдал	х		х	х		х				х
Эрдэс түүхий эдийн нөөц	х				х		х			х
Эрчим хүчний нөөц					х					х
Байгаль орчны нөлөөлөл										
Ундны усны чанар, хэмжээ	х		х		х					х
Агаарын бохирдол	х			х				х		
Хөрсний элэгдэл, эвдрэл	х			х			х	х		
Хог хаягдлаас үйдэлтэй бохирдол, доройтол	х			х		х			х	
Дуу чимээ, шуугианы нөлөө	х			х					х	
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	х				х				х	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	х				х				х	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх		х								
Нийгэмд үзүүлэх нөлөө										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	х				х		х		х	
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		х			х				х	
Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх	х				х		х		х	
Ажилтай иргэдийн тоо нэмэгдэх	х				х					х

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагддаг	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Эдийн засагт үзүүлэх нөлөөлөл										
Татварын орлого өөрчлөгдөх	х				х				х	
Орон нутгийн орлого нэмэгдэх	х				х		х		х	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	х			х						х
Ажлын байр нэмэгдэх	х				х				х	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	х			х			х			х
Бусад нөлөөлөл										
Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	х				х		х	х		
Уурхайн болон ахуйн бохир уснаас хөрс ба грунтын усыг бохирдуулах		х			х	х				х
Шатахууны алдагдлаар хөрс бохирдох	х				х		х			х
Дүн	24	3	6	8	19	5	11	5	12	11

Шууд нөлөөлөл:

Болзошгүй нөлөөллийн 24 (76.0%) шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Нүүрсний ордоос нүүрс олборлохын тулд хөрс хуулах, геологийн тогтоцыг шууд өөрчлөх, газрын доорх ус, хөрс ургамлын бүтцийн өөрчлөлт, эвдрэл гарах, бэлчээр болон эрдэс түүхий эдийн нөөц, агаарын ба хөрсний бохирдол зэрэг байгалийн төлөв байдал, байгалийн өнгө төрх, ландшафтад сөргөөр нөлөөлөх муу талтай байна.

Шууд бус нөлөөлөл:

Нийт нөлөөллийн 3 (11.0%) нь шууд бус нөлөөлөлд хамрагдах бөгөөд тэсэлгээний үед гарах болон нэг дор ажиллаж байгаа хүнд механизмуудын дуу чимээний нөлөөгөөр зэрлэг ан амьтан үргэж дайжих, газрын доорх усны нөөц чанарт нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөлөл байгаагаас гадна орон нутгийн нийгэм-эдийн засагт, (хүн амын тоо, бодит орлого

нэмэгдэх, үйлдвэр үйлчилгээний салбарын үйл ажиллагааг нэмэгдүүлэх г.м) эерэг нөлөөлөхөөр байна.

Богино хугацааны нөлөөлөл:

Халаалтын зуух, хүнд механизмуудаас агаарт бохир утаа хаягдах, хөрс бохирдох, өрөмдлөг тэсэлгээний үед, болон хөрс чулуу ачих, тээвэрлэх явцад тоос босох, дуу чимээ гарах зэрэг сөрөг нөлөөллүүд нь богино хугацааны нөлөөлөлд багтана. Үүний зэрэгцээ хур бороо багатай агаар хуурайшсан салхитай үед хөрсний овоолго, уурхайн мөргөцөг ба ажлын түвшин, уурхайн дотоод зам зэргээс тоос шороо хийсэх, мөн тэсэлгээний үед их хэмжээний тоос босдог нь ажиллагсадын эрүүл мэнд, орчны хөрс ургамлын бүрхүүлд нөлөөлнө.

Урт хугацааны нөлөөлөл:

Нүүрсний ордын олборлолтыг одоогийн тооцоогоор ашиглахад олон жилийн нөөцтэй тул байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн ихэнх буюу 19 (89.3 %) нь урт хугацааны нөлөөлөлд хамаарч байгаа бөгөөд энэ нь бараг бүгдээрээ буцалтгүйгээр байгаль орчин, орон нутгийн нийгэм-эдийн засагт нөлөөлөхөөр байна.

Иймээс уурхайд олборлолт хийх үед байгалийн унаган төрхийг алдагдуулан, хөрс ургамлын бүтцийг өөрчлөлт элэгдэл эвдрэлд оруулах зэрэг сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх ажлыг нарийн дэс дараатай хийх шаардлагатай болно.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО

Тус БОМТ нь “Шивээ-Овоо”-гийн ил уурхайн хүрэн нүүрсний ордыг ашиглаж төвийн эрчим хүчний систем дэх томоохон хэрэглэгчдын нүүрсний хэрэгцээг чанар стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн хангах, улс болон орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах зорилготой.

“Шивээ-Овоо” ХК нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараахь арга хэмжээг хэрэгжүүлэх зорилготой. Үүнд:

1. Уурхайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах.
2. Нарийвчилсан үнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг бодит байдал дээр тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх.
3. Шивээ-Овоо ХК-ийн байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх.

4. Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамаарал, хамрах хүрээг гэрээт байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тодорхойлох.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт №5

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил	Гарах үр дүн	Үнэлгээнд эзлэх жин, %	Хариуцах эзэн	Аргачлал, стандарт
Агаар				
Зам, талбайг усалж, чийглэх.	Тоосжилт буурна.	20	АЗ-ын инженер, ХАБЭА	
Уурхайн тоосжилт ихтэй орчинд Шивээ-говь сумын БОМ-ий хяналттай мониторингийн цэг тогтоон агаарын тоосны сорьц авч тодорхойлуулах.	Агаарын чанарыг хянана.	ОХШХ-т тусгасан	Байгаль орчны мэргэжилтэн	Агаарын тухай хууль <input type="checkbox"/> MNS 4585:2007 <input type="checkbox"/> MNS 5365:2005 <input type="checkbox"/> MNS 5885:2008
Түлшээр ажилладаг тоног төхөөрөмжүүд ээс ялгарах утааны хэмжээг хянаж, яндангийн шүүр зэргийг тогтмол шалгаж, эвдэрсэн эд ангийг шинэчилж байх.	Тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулна.	30	Ерөнхий механик, Байгаль орчны мэргэжилтэн	<input type="checkbox"/> MNS 5013:2009 <input type="checkbox"/> MNS 5014:2009 <input type="checkbox"/> MNS 4601:2011

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил	Гарах үр дүн	Үнэлгээнд эзлэх жин, %	Хариуцах эзэн	Аргачлал, стандарт
Тэмдэгжүү лэлт хийх, сайжруулах.	Олон салаа зам гаргахаас сэргийлж, тоосжилт нэмэгдэхээс сэргийлнэ.	20	ХАБЭА, Замын инженер	MNS 4595:2007
Байнгын ажиллагаатай зам, талбай, зогсоолын хучилтыг сайжруулах, арчилах.	Орчны тоосжилтыг бууруулна.	30	Замын инженер, АБХ	
Нүүрсний өөрөө шаталтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.	Агаарын чанарт нөлөөлөх хорт хийг бууруулна.	ОХШХ-г тусгагдсан	Байгаль орчны мэргэжилтэн, УНХ	Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага. MNS 4585:2007
Хөрс, газрын хэвлий				
Эвдрэлд орсон газрын хөрсийг нөхөн сэргээх.	Хөрсний үржил шим сайжрана.			
Шимт хөрсийг ангилан хуулах.	Нөхөн сэргээлтэнд шаардлага тай шимт хөрсний нөөц бүрдэнэ.	40	УНХ, АБХ Байгаль орчны мэргэжилтэн	MNS 5917:2008 MNS 5914:2008 MNS 5915:2008 MNS 5916:2008
Шимт хөрсийг тусад нь овоолж хадгалах.				
Гадаад овоолгын суурийн талбайн шимт хөрсийг хуулах.				

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил	Гарах үр дүн	Үнэлгээнд эзлэх жин, %	Хариуцах эзэн	Аргачлал, стандарт
Хөрс шорооны овоолгыг төлөвлөсөн талбайд эмх цэгцтэй хийх.	Хөрсний элэгдэл, эвдрэлээс хамгаална.	30	ХАБЭА, Байгаль орчны мэргэжилтэн	MNS 5916:2008
Шатах, тослох материалын хадгалалтад хяналт тавих, орчныг тусгай хучилттай болгох.	Хөрсний бохирдлоос хамгаална.	20	АБХ, ЗасХ, ТҮХ, ШТС-ийн эрхлэгч	MNS 5916:2008
Хөрсний дээж авч бүтэц, шинж чанарыг орчны хяналт шинжилгээг Шивээ-говь сумын БОМ-ий хяналтын дагуу тодорхойлуулах.	Хөрсний эвдрэл бохирдлоос хамгаална.	ОХШХ-т тусгасан	ХАБЭА, Байгаль орчны мэргэжилтэн	MNS 3310:91 MNS 5916:2008
Бороо болон үерт хөрс эвдрэхээс хамгаалах далан, шуудуу татах.	Хөрсний эвдрэлээс сэргийлнэ.	10	УНХ, АБХ	-

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил	Гарах үр дүн	Үнэлгээнд эзлэх жин, %	Хариуцах эзэн	Аргачлал, стандарт
Ус				
Талбайн АБХ, ЗХ орчимд хатуу ба шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн хаяхгүй байж, гадаргын уст цэгийн орчныг цэвэрлэх.	Усны бохирдлоос хамгаална.	20	Байгаль орчны Мэргэжилтэн, АБХ, ЗХ, УНХ, ШТС	Ариун цэврийн тухай хууль □MNS 5775:2007
Усны шинжилгээг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заасны дагуу Шивээ-говь сумын БОМ-ий хяналттай хийлгэх.	Усны бохирдлоос урьдчилан сэргийлнэ.	ОХШХ-г тусгасан	Байгаль орчны мэргэжилтэн	
Харьяа байгууллагатай ус ашиглах гэрээ байгуулж ус ашигласны төлбөр төлөх.	Усны нөөцийг хамгаалах, усан сан бүхий газрыг нөхөн сэргээх, зам усалгаанд зарцуулна.	Ус ашиглах дүгнэлт гэрээний дагуу	Ерөнхий инженер, Ерөнхий ня-бо, Геологич	Усны тухай хууль
Худагт тоолуур суурилуулах, Баталгаажуулах.	Усны үр ашигтай зарцуулалт нэмэгдэх, усны нөөцийг хамгаална.	50	УНХ, УШХ, Геологич	Усны тухай хууль, Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил	Гарах үр дүн	Үнэлгээнд эзлэх жин, %	Хариуцах эзэн	Аргачлал, стандарт
Уурхайн ойролцоо хяналтын цооногт газрын доорхи усны төвшингийн өөрчлөлтөнд хяналт тавих.	Гүний усны бохирдлоос хамгаална.	30	Байгаль орчны мэргэжилтэн, УШХ	Усны тухай хууль, Ариун цэврийн тухай хууль,
Ургамал, амьтан				
Уурхайн олборлолтын талбайн талхлагдсан газруудад олон наст ургамлын үр тариалж ургамалжуулах, орчныг тохижуулах, мод бут сөөг тарих.	Ургамалан Бүрхэвчийн доройтлоос сэргийлнэ.	Нөхөн сэргээлтийн зардалд тусгагдсан	Байгаль орчны мэргэжилтэн, Хүний нөөцийн алба	MNS 5914:2008
Шинэ усны хэсгийн талбай, түүний эргэн тойронд зэрлэг ан амьтадын хяналт шинжилгээ хийх, маршрутын судалгаа хийх.	Төмөр зам болон авто тээврийн замд амьтан өнгөрөх гарцанд тэмдэг тэмдэглэгээг хийх арга хэмжээг төлөвлөнө.	БОНБНУ-нд тусгагдсан	Байгаль орчны мэргэжилтэн	Байгаль орчныг хамгаалах тухай хууль

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт №6

№	Үйл ажиллагаа	Хамрах хүрээ	Төсөв /мян. Төг/	Аргачлал, стандарт
Техникийн нөхөн сэргээлт				
1	Уурхайн малталтанд өртөх талбайн шимт хөрсийг ангилан хуулах, ачих.	Хөрс хуулах талбай	Уул ажлын төлөвлөгөөнд тусгагдсан	Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008
2	Шимт хөрсийг тусад нь овоолж хадгалах.	Шимт хөрсний овоолго	Уул ажлын төлөвлөгөөнд тусгагдсан	Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008
3	Шимт хөрсний овоолгын гадаргыг хамгаалж ургамалжуулах.	2 жилээс дээш хугацаагаар ашиглахгүй шимт хөрсний овоолго	Уул ажлын төлөвлөгөөнд тусгагдсан	Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008
4	Уурхайн ашиглалтанд өртсөн орон зайг дотоод овоолгоор дүүргэж хэлбэржүүлэх.	Ашиглалтанд өртсөн талбай	Уул ажлын төлөвлөгөөнд тусгагдсан	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт MNS 5914:2008
5	Хэлбэржүүлсэн талбайг шимт хөрсөөр хучих, тэгшилгээ хийх.	Бэлтгэгдсэн талбайд	Уул ажлын төлөвлөгөөнд тусгагдсан	Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5915:2008

№	Үйл ажиллагаа	Хамрах хүрээ	Төсөв /мян. Төг/	Аргачлал, стандарт
Биологийн нөхөн сэргээлт				
1	5 га талбайд Биологийн нөхөн сэргээлт хийх, олон наст ургамлын үр авах.	Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбай	15 000.0	Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шардлага MNS 5918:2008
2	Шүүрүүлэхийн усны хаялбарын шуудууг бетондох, нөхөн сэргээх зардал. /2 га талбайд/	Хаялга нуурын орчим	37 800.0	Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шардлага MNS 5918:2008
3	Уурхайн захиргаа, бусад барилга байгууламж бүхий талбайд мод тарих зүлэгжүүлэх, тохижуулах.	Уурхайн захиргаа, үйлчилгээний орчин	15 000.0	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008
4	Усалгаа, арчилгаа, тордолт хийлгэх 2 гэрээт ажилтан авах.	Биологийн нөхөн сэргээлт, мод таригдсан талбай	16 800.0	
5	Усалгаа, арчилгаа, тордолт хийх.	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай	Дотоод зардалд тусгагдсан	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008
Нийт			84 600 мян.төг	

Техникийн нөхөн сэргээлт

“Шивээ-Овоо” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 7-р сарын тогтоолоор батлагдсан Байгаль орчны журмын 4.9-ийн 4.9.8, 4.9 .9-д заасны дагуу компанийн тухай хуулийн 83-р зүйлийн 83.1, Хөдөлмөрийн дотоод журмын 3-р зүйлийн 3.1 дэх заалт, Захирлын зөвлөлийн 2018 оны 8-р сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрээр А/82-ийн 1-р хавсралт тушаалаар батлагдсан “Уурхайн нөхөн сэргээлтийн аргачилал”-ын дагуу хийгдэнэ.

2019 оны техникийн нөхөн сэргээлтийн ажлыг дараах чиглэлүүдээр уулын ажлын төлөвлөгөөнд тусган, компанийн бизнес төлөвлөгөөнд зардлыг суулгаж хийхээр төлөвлөж ажиллах болно. Үүнд:

1. Шимт хөрсийг хуулах

1.1 Уулын ажлын төлөвлөгөөний дагуу 4-11 сарын хооронд шимт хөрс хуулалтыг уулын ажлын ахилтанд орох хайгуулын IX-XIII шугамын хоорондох 6 га талбайгаас 20.0 мян.м³ шимт хөрсийг 0.33 м-ийн зузаантайгаар хуулж биологийн нөхөн сэргээлт хийх талбайд байршуулна. Овоолгын 6 га талбайгаас 20.0 мян.м³ хөрсийг 0.33 метрийн зузаантайгаар хуулж агуулахад байрлуулна.

Шимт хөрс хуулалтанд ажиллах тоног төхөөрөмжүүд

1.2 Шимт хөрсийг уурхайд ашиглагдаж байгаа хүнд машин механизм, бульдозероор хуулж, ачиж тээвэрлэх ажлыг дугуйт ачигч, гидроэкскаватор, технологийн автомашинуудаар гүйцэтгэнэ.

2. Нөхөн дүүргэлт

2.1 Тээвэргүй хөрс хуулалтанд ЭШ-25/90, ЎØ-11/70 àëðàà÷ ýêñåààðîðààðд олборлолтын орон зайд нөхөн дүүргэлтийн ажил хийгдэнэ.

ЎØ-25/90 àëðàà÷ ýêñåààðîðààðд àø èàëàëðòó í 2-р амны хайгуулын IX-XI шугамын хооронд 4.6 га талбайд 1479.2 мян м³, ЎØ-11/70 àëðàà÷ ýêñåààðîðààðд ашиглалтын 3-р амны хайгуулын XI-XIII шугамын хооронд 2.2 га талбайгаас 723.0 мян м³ хөрсийг нөхөн дүүргэлтэнд хийгдэнэ.

Нөхөн дүүргэлтэнд ажиллах тоног төхөөрөмжүүд

2.2 ЭШ-25/90, ЭШ11/70 алхагч экскаваторууд, мөн эдгээр экскаваторуудын ажлын мөргөцөг бэлтгэх зорилгоор тээвэртэй хөрс хуулалтыг хайгуулын VIII-XIII шугам хооронд 3ш ЭКГ - 5А, 1ш ЭКГ-10И экскаватор, авто самосвалын хослолоор хийхээр төлөвлөж хийгдсэн.

Техникийн нөхөн сэргээлтийн дүүргэлт

1-р амны хойд талын 3-н га талбайд 30 мян.м³ шороогоор нөхөн дүүргэж, биологийн нөхөн сэргээлт хийх шимт хөрс 6 мян.м³ тээвэрлэж буулгах.

3. Хөрсний гадаад овоолгыг нөхөн сэргээх дараах боломжит чиглэлүүд

3.1 Нутгийн олон наст ургамал тарьж ургамалжуулан малын бэлчээр болгох.

3.2 Эхний ээлжинд гадаад овоолгын 10% орчимд туршилтын журмаар мод, бут, төрөл бүрийн олон наст ургамлын төрөл зүйлийг тарьж үзэх бөгөөд ашиглалтын жилүүдэд шинэ төрөл зүйлийн ургамал тарих талбайг нэмэгдүүлэх боломжтой эсэхийг шийдэх болно.

3.3 Гадаад овоолгын хажуугийн налууугийн өнцөг нь дунджаар 34-36° байх бөгөөд энэ нь овоолгыг бүрдүүлэгч чулуулгуудын байгалийн нурлын өнцөг юм.

3.4 Хөрс боловсруулах, машин техник ажиллуулахад зөвшөөрөгдөх хэмжээний хэвгий үүсгэх зорилгоор овоолгын гадаргыг тэгшилнэ. Овоолгын хажуугийн өнцгийн хамгийн дээд хэмжээг ургамлын ургалт, газар шорооны ажлын хэмжээ болон бусад нөхцөл зэргээс үндэслэн 22° байхаар тооцов.

3.5 Хөрсний овоолгыг тэгшлэн налуулж хэлбэршүүлсний дараа бороо хур тунадасны илүүдэл усыг зайлуулж элэгдэл эвдрэлээс хамгаалах сувгийг овоолгын гадаргуу дээр татна.

Биологийн нөхөн сэргээлт

2019 онд Уулын дотоод овоолгын 5 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийнэ.

“Шивээ-Овоо” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 7-р сарын тогтоолоор батлагдсан Байгаль орчны журмын 4.9-ийн 4.9.8, 4.9.9-д заасны дагуу компанийн тухай хуулийн 83-р зүйлийн 83.1, Хөдөлмөрийн дотоод журмын 3-р зүйлийн 3.1 дэх заалт, Захирлын зөвлөлийн 2018 оны 8-р сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрээр А/82-ийн 1-р хавсралт, А/83-ийн 5-р хавсралт тушаалаар батлагдсан “Уурхайн нөхөн сэргээлтийн аргачилал”, “Шимт хөрстэй ажиллах заавар”-ын дагуу хийгдэнэ.

Биологийн нөхөн сэргээлтийг хийхдээ овоолгыг орчин тойрны байгалийн үзэмжийг эвдэхгүй, бэлчээрийн зориулалтаар ашиглаж болохуйцаар хэлбэржүүлэн хийнэ.



1.Тариалалтын өмнөх тэгшилгээ

Шимт хөрсийг хучсаны дараагаар Автогрейдер болон бульдозероор талбайг тэгшилж тариалалтанд бэлдэнэ.

2.Агротехникийн боловсруулалт

-Техникийг механик эвдрэлээс сэргийлэн том хэмжээний чулууг түүж зайлуулна.

-30 метр тутамд 4 м-ийн өргөнтэй хөндлөн огтлол бүхий үерийн далан байгуулна.

3.Тариалалт

Олон наст ургамлын үрийг нэг наст ургамлын үртэй холин га-д дунджаар 45-55 кг тооцоолон 2.0-2.5 см гүнд үрлэнэ. Үрийг салхинд хийсэхээс хамгаалан бөёяаæ ÷ëã ðàì ååàёна.

Техникээр явах боломжгүй газар гар тариалалт хийнэ.

4.Нөхөн тариалалт

Хур борооны улмаас эвдэрч урссан хэсгүүдийг сэргээн засаж техникээр болон гараар нөхөн тариалалт хийнэ.

5.Мониторинг

Нөхөн сэргээсэн талбайд байнгын хяналтын цэг байгуулан жил бүр ургамлын тооллого хийн ургамалжилтын бүртгэл хөтөлнө.

Нөхөн сэргээлтийн үндсэн шаардлага хангасан үед орон нутгийн засаг захиргаанд хүлээлгэн өгнө.

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний ерөнхий хуваарь

Нөхөн сэргээлтийн төлөвлөлт нь дараахь дэс дараатайгаар хэрэгжинэ:

Оны эхэнд, өвөл:

- Жилийн нөхөн сэргээлтийн /нарийвчилсан/ төлөвлөгөө боловсруулах
- Мөчир бэлтгэх
- Нарийвчилсан судалгаа хийх, мэргэжлийн байгууллагуудтай нөхөн сэргээлт, хог хаягдлын саармагжуулалт, тоосжилтыг багасгах чиглэлээр хамтран ажиллах бэлтгэлийг хангах

Хавар:

- Туслах хүн хүчний асуудлыг шийдвэрлэх
- Компост бэлтгэх
- Модлог ургамлыг бордоогоор бордох
- Суулгац шилжүүлэн суулгах бэлтгэл ажил /шуудуу бэлтгэх/,

- Гүний худаг өрөмдүүлэх, тоноглох, тоолууржуулах /зөвшөөрөл авах/
- Хашаа хайсыг засч янзлах, будах, өргөтгөх
- Техникийн бэлэн байдлыг хангах: анжис, борной угсарч бэлтгэх
- Нутгийн ургамлын үр цуглуулах /Орон нутгаас зөвшөөрөл авах/
- Тарималжуулах талбайд хэлбэржүүлэлт хийх /шимт хөрсний гадарга/

Зун:

- Усалгааны системийн ажиллагааг хянах, засварлах, үнэлэх
- Тарималжуулах туршилтын явцын үнэлгээ хийх, тэмдэглэл хөтлөх
- Таримал ургамлын усалгаа арчилгааг үргэлжлүүлэх

Намар:

- Цэнэг усалгаа хийх
- Модлог ургамалын тарьц бүхий талбайд бордоо хэрэглэх
- Нутгийн ургамлын үр цуглуулах
- Тарималжуулах туршилтын үр дүнг дүгнэх

Өвөл:

- Мөчир бэлтгэх
- Тайлагнах, төлөвлөгөө боловсруулах

Туршилтын үр дүнг тариалсан ургамлын ургалтын эрчмийг долоо хоног, сар, улирлаар хянаж, дасан зохицох чадвар, өвөлжилтийн байдал, сэргэн ургалтаар, бордоог компостгүй болон компосттой ургамалд зэрэгцүүлэн турших замаар үнэлэх бөгөөд мэргэжлийн байгууллагын туслалцааг авна.

Ажлын график

Хүснэгт №7

Хугацаа Хийгдэх ажил	1-р улирал		2-р улирал			3-р улирал			4-р улирал
	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар
Шимт хөрс хуулалт									
Нөхөн дүүргэлт									
Бульдозерын хэлбэржүүлэлт									
Тэгшилгээ									
Шимт хөрсөөр хучих									

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах газрыг сонгохдоо экологийн хувьд ижил байх, нөлөөлөлд өртсөн газартай ойр байх, хугацааг нөлөөлөлтэй харьцангуйгаар тогтоох зарчмыг баримтлана. Мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө нь манай уурхайн нөхцөлд хийгдэхгүй учир нь Биологийн нөхөн сэргээлт хийгдэх талбай байгаа болно.

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэхгүй. Өөрийн эдэлбэр газарт үйл ажиллагаа явуулж байгаа болно.

Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын талбайн орчинд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй байна. Цаашид ашиглалтын явцад түүх, соёлын өвтэй холбоотой олдвор, дурсгал илэрсэн тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу арга хэмжээг авч ажиллана.

ХИМИЙН БОДИСЫН МЕНЕЖМЕНТ

Уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хэмжээнд ашиглагдаж байгаа химийн агууламж бүхий бодис, материал, хог хаягдлыг бүртгэлжүүлж мэдээллийн сан бүрдүүлэн ажиллана. Химийн бодисын агууламж бүхий бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтанд холбогдох хууль болон дотоод журмын дагуу хяналт шалгалтаар тогтмол хяналт тавьж ажиллах.

2019 онд төслийн хэмжээнд химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж мөрдөж ажиллана.

ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Химийн бодис

Шивээ-Овоогийн уурхай нь химийн бодис ашигладаггүй бөгөөд нүүрсний шинжилгээний лабораторид 15 нэр төрлийн хуурай болон уусмал байдалтай бодис хадгалагдаж байна.

Нүүрсний шинжилгээний лаборатори нь нүүрсний чийглэг, үнслэг, илчлэг, дэгдэмхий, хүхэр зэрэг шинж чанарыг шинжлэх, бутлуурын өрөөнүүдэд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд химийн бодис, урвалжуудыг шкафанд төрөлжүүлэн хадгалж, шкафны хаалган дээр хаяг шошго, аюулын тэмдэглэгээ, шкафны тавиур бүрт хадгалагдаж байгаа бодисын нэр, химийн томъёо, хэмжээ, аюулын зэргийг тодорхой бичиж хадгалж байх. Лабораторид байгаа химийн бодисыг жилд 1 удаа тоолон хадгалалтын хугацаа дууссан химийн бодисуудыг Аймгийн Мэргэжлийн Хяналтын албанд хүсэлт гарган, мэргэжлийн байгууллагаар устгуулдаг байх.

Байгаль орчны мэргэжилтнүүд эрсдэл бүхий объектуудыг холбогдох нэгжийн ажилтнуудтай хамтран шалгаж эрсдлийн үнэлгээг хийж гүйцэтгэж байх.

2018 оны 8-р сарын 22-ны өдрийн Захирлын зөвлөлийн хурлаар “Химийн бодис, тос тосолгооны материалын асгаралтын журам” А/81 тоот тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллах.

Мөн Аюултай бодисын худалдан авалт, хадгалалт, хэрэглээний журам боловсруулан батлуулж, асгаралтын иж бүрдлийг худалдан авч уурхайн шаардлагатай газруудад байрлуулж ажиллах.

Оүйдүй материалын агуулахын тухай товч тодорхойлолт

“Шивээ-Овоо” ХК нь 2014 онд “Шивээ-Овоо” нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, нүүрсний уурхайд гүйцэтгэдэг тэсэлгээний ажлын зардлыг бууруулах зорилгоор өөрийн хэрэгцээнд зориулан “Энгийн найрлагат тэсрэх бодисын үйлдвэр” байгуулан ажиллаж байгаа болно. Тэсрэх бодисын үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний ажлыг “Шинчи-Баян” ХХК гүйцэтгэсэн. Төслийн талбайн нь Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт,” Шивээ-Овоо” нүүрсний уурхайн талбайн хойд захад байрлана. Шивээ-Овоогийн уурхайн нь Улаанбаатар хотоос урд зүгт 260 км зайд, Чойр хотоос 20 км зайд оршино.

“Шивээ-Овоо” ХК нь энгийн тэсрэх бодисын үйлдвэрээ Тэсэлгээний аюулгүйн ажиллагааны нэгдсэн дүрмийн шаардлагын дагуу байнгын их хөдөлгөөнтэй авто-зам, улсын чанартай объект, хүн ам бүхий суурингаас нэг километр зайтай, уурхайн эдэлбэр газарт талбайн баруун хэсэгт уулын ажлын эцсийн хүрээнээс баруун тийш 5 км зайд 4.2 га талбайд байгуулахаар төлөвлөж байна. Талбайг тойруулан хашаа татсан бөгөөд хашаан дотор байрлах хамгийн захын барилга нь хашаанаасаа 40 м зайтай байрлана гэж төлөвлөсөн. Хашааны гадна эргэн тойрон 50 м-ийн зай бүхий газарт хориотой бүс тогтоосон ба түүн дотор хашаанаас 5 м-ийн зайд 0.5 м гүн суваг тойруулан татсан. Үйлдвэрийн талбайг нийтэд нь хянах боломж бүхий өндөрт байрласан харуулын байртай. Үйлдвэрийн барилга байгууламжуудын хооронд байх аюулгүйн зайг хүчин төгөлдөр мөрдөж буй норм, Монгол Улсын Тэсэлгээний ажлын нэгдсэн дүрэм-д заасан аргачлалаар тооцож тогтоосон. Хог хаягдлыг хадгалах саваар хангагдсан байх ба цэвэрлэгээг тогтмол хийлгэж байх.

Эрсдлийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө

Эрсдлээс урьдчилан сэргийлэх болон түүнийг бууруулах, арилгах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Химийн бодис, тэслгээний материалын ашиглалт, зарцуулалтын бүртгэл хөтөлж, тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хүргүүлэх.
- ОБЕГ-ын Гамшиг судлалын хүрээлэнгээр тэсэрч дэлбэрэх бодисын эрсдлийн төлөвлөгөө хийлгэх.
- Тэсэлгээний материал хадгалдаг агуулахад байнгын 24 цагийн өндөржүүлсэн бэлэн байдлын харуултай байлгах.
- Химийн бодисын хадгалалт, сав баглаа боодлыг гэмтээхгүй байх, байнгын хяналт тавих, шошго тэмдгийг бүрэн бүтэн байлгах.
- Химийн бодис, тэсэлгээний материалтай харьцаж ажилладаг хүмүүст хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журам, тухайн бодис материалын шинж чанар үзүүлж болох хорт чанар, хамгаалах арга, анхны тусламжийн талаар тусгайлан хичээл заах.
- Химийн бодис, материалтай харьцаж ажилладаг ажиллагсдад ажлын хувцас, хошуувч, баг, нүдний шил, нүүрний хамгаалалт, хормогч, бээлий зэрэг хамгаалах хэрэгслээр хангах, тэдгээрийг тогтмол хэрэглүүлэх.

- Химийн бодис, тэсэлгээний материалыг битүүмжлэл сайтай, салхивчийн системтэй, зориулалтын байр, агуулахад хадгалах.
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, галын аюулаас хамгаалах журмыг ажиллагсдад танилцуулах.
- Болзошгүй аваарь ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах.
- Онцгой байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллах.

Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог, хаягдлын байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Ажилчидын хотхоноос гардаг нойтон хог хаягдал нь дулааны улиралд орчны агаарт эвгүй үнэр тархах магадлалтай.
- Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаас ялгарах утаа нь агаарт тоосонцорын хамт хаягдана.
- Бохир ус цэвэрлэх байгууламжаас гарч байгаа үнэр орчинд тархах.

2. Хөрсний элэгдэл, эвдрэл:

- Хог хаягдлыг хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааны улмаас хөрсний чанар доройтож болзошгүй.

3. Ургамал амьтанд үзүүлэх нөлөөлөл:

- Барилга байгууламжийн талбайн хэмжээгээр хөрс, ургамалан бүрхэвч устсан. Уурхайн бусад хэсгээс ахуйн хог хаягдал зөөвөрлөгдөн ирж болзошгүй ба тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсч, ургамалан бүрхэвч дарагдаж болзошгүй.

4. Хог хаягдлын нөлөөлөл:

- Хог хаягдлын менежментийн үндсэн үйл ажиллагаа нь төслийн үйл ажиллагаанаас үүссэн төрөл бүрийн хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашиглах боломжгүй хог хаягдлыг шатаах, хог хаягдлын төвлөрсөн цэгт хаях арга хэмжээг авах юм.

Зорилго

Уурхайн ажилчид, гэрээт байгууллагуудын хүрээнд Монгол улсын ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартуудыг хангуулж, үйлдвэрийн газрын хэмжээнд сахин мөрдүүлнэ.

Энэ зорилгын хүрээнд дараах ажлуудыг байнга хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Аюултай хог хаягдал үүсэхээс зайлсхийх, хор хөнөөлийг бууруулах:
- Зайлсхийх боломжгүй хог хаягдлыг дахин боловсруулах, хор хөнөөлийг саармагжуулах, байгаль орчинд халгүй байдлаар зайлуулах:
- Хог хаягдлыг зайлуулах гуравдагч этгээдэд байгаль орчинд халгүйгээр гүйцэтгэх гэрээ, явцад нь хяналт тавих.

Зарчим

- Үйлдвэрээс гарах хог хаягдлын хэмжээг багасгах зорилгоор эх үүсвэр дээр нь ангилан ялгалт хийх.
- Орчны бохирдлоос сэргийлэх зорилгоор хог хаягдлыг ил хаяхгүй байх, тусгай тэмдэглэгээ бүхий хогийн саванд хийх.
- Байгальд удаан хугацаагаар шингэдэггүй хаягдлыг, дахин боловсруулалтанд нийлүүлэх болон аюултай хог хаягдлыг урьдчилан саармагжуулах арга хэмжээ авч ажиллах.
- Хог хаягдлын урсгал болон ангилан ялгалтыг хянах зорилгоор бүртгэлүүдийг сайжруулах, баримтжуулах.
- Уурхайд ашиглагдаж байгаа усны чанар, бүтээгдэхүүн, хаягдлын хорын чанарт хяналт тавьж ажиллах.
- Говь-Сүмбэр аймаг болон Шивээ-говь суманд үйлдвэр, үйлчилгээний газруудын хог хаягдал хүлээн авч ангилан ялгах, дахивар боловсруулах байгаль орчинд сөрөг нөлөөгүй парк байгуулах боломжийг эрэлхийлэн судлах.

Цаашид хог хаягдлын менежментийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

Үүнд:

- Хог хаягдлыг ангилан ялгах, техникийн сэлбэгийн хаягдлыг ялган ашиглах боломжтойг авч үлдэн, ашиглах боломжгүйг нь 2 дахь түүхий эдийн хашаанд хадгалах, ХХА нь зарж борлуулах.

- Шингэн хог хаягдыг эргүүлэн ашиглах технологийг судлах.
- Уурхайн эмнэлэгийн аюултай хог хаягдлыг Шивээ-говь сумын нэгдсэн эмнэлэг хургүүлэн журнал хөтлөн тэмдэглэх.
- Хог хаягдлын журмыг шинэчлэн боловсруулж, мөрдөж ажиллуулах.
- Ахуйн хатуу хог хаягдлыг түр хадгалах гурван цэгт байршуулж, Шивээ сервис компани-д хүлээлгэн өгөх.

Хог хаягдлын төрөл

Аюултай төрөлд хамаарах хог хаягдлын жагсаалт

А. Дахин ашиглагдах

- Хаягдал тос
- Тосны төмөр болон хуванцар торх
- Ашигласан дугуй
- Аккумулятор болон принтерийн хор

Б. Дахин ашиглагдахгүй

- Тос тосолгооны материалаар бохирдсон даавуу, бээлий, алчуур
- Тосны шүүр, тос шингээгч материалууд
- Хортой химийн бодис агуулсан хаягдал, бохирдсон хөрс

Аюулгүй хог хаягдлын жагсаалт

А. Дахин ашиглагдах

- Модны хаягдал, модон болон картон хайрцаг, цаас
- Цэвэр ус, ундааны хуванцар сав, төмрийн хаягдал
- Техникийн шүүр, нойтон хог хаягдал

Б. Дахин ашиглагдахгүй

- Агааржуулагчийн сав, хагарсан, шатсан гэрлийн шил
- Бусад ахуйн хуурай хог хаягдал, хөөсөнцөр зөөлөвч

ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- “Шивээ-Овоо” ХК-ий охин компани болох “Шивээ-Сервис” ХХК-тай гэрээ байгуулсаны дагуу улирал тутамд ахуйн хогоо ачуулж зайлуулж байна. Цаашид гэрээгээ сунган хамтран ажиллана.

- Компаний 2018 оны 8-р сарын 22-ны А/80 тоот Захирлын зөвлөлийн хурлын шийдвэрээр батлагдсан “Хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах журам” баримтлан ажиллана.

- Гэрээний дагуу улиралд 1 удаа хоёр тал хог хаягдлын хэмжээг бүртгэл хийж баталгаажуулдаг байх.

- Хог хаягдлыг тээвэрлэхдээ, ахуйн хог хаягдлыг тээвэрлэх ерөнхий шаардлага /MNS 5344:2011/ стандартыг мөрдлөг болгон ажиллана.

- Хог хаягдлын бүртгэлийг хог хаягдал тээвэрлэлтийн бүртгэлийг хөтөлж мэдээллийн сан үүсгэж ажиллана. Цаашид мэдээллийг бүртгэлжүүлж ажиллана.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Нойтон хог хаягдлыг тодорхой хугацаанд түргэн шуурхай, гэрээт аж ахуй эрхлэгчид нийлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх.

- Утаа бага ялгаруулдаг бүрэн шаталттай шатаах зуухны үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих.

- Бохир ус цэвэрлэх байгууламжид тогтсон хугацаанд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх.

Хөрсний элэгдэл, эвдрэл:

- Хог хаягдлыг хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.

- Тогтсон маршрутын дагуу хог ачих үйл ажиллагааг явуулах.

- Хог хаягдлыг хадгалах зайлшгүй шаардлагатай нөхцөлд холбогдох арга хэмжээг авч түр хадгалах.

Ургамал амьтанд үзүүлэх нөлөөлөл:

- Зөвшөөрөгдсөн маршрутын дагуу тээвэрлэлт хийх. Шаардлагатай газруудад замыг тогтмол услах арга хэмжээг авч ажиллах.

Хог хаягдлын нөлөөлөл:

Компанийн дотоод журмын дагуу холбогдох арга хэмжээг авч, хяналт тавьж ажиллах.

Хог хаягдлын их цэвэрлэгээ:

- Хог хаягдлын их цэвэрлэгээг тогтмол давтамжтай хугацаанд хийх.
- Хог хаягдлын тээвэрлэлттэй уялдуулан хийх арга хэмжээг авч ажиллах.
- Цэвэрлэгээний ажилд тээврийн машины жолооч нартай хамтран ажиллах.
- Шаардлагатай газруудад хог хаяхыг хориглосон нэмэлт тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах.
- Сум орон нутгаас зохион байгуулж байгаа хог хаягдлын цэвэрлэгээний ажилд идэвх санаачлагатай оролцож, тайлан мэдээг холбогдох ажилтнуудад хүргэж ажиллах.
- Хог хаягдал хаях савнуудын тоо хэмжээг нэмэгдүүлэх, тэмдэг тэмдэглэгээг сайжруулах.

ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ, ТӨСӨВ

Хүснэгт №8

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэгч	Баримтлах хууль, журам, стандарт
Ахуйн хатуу хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан хаях, хогийн цэгүүдийг байрлуулах.	4 000.0	Байгаль орчны мэргэжилтэн	Хог хаягдлын тухай хууль, Хог хаягдлыг ангилан ялгаж хаях журам
Хог хаягдлын цэг, бохирын цооногт тогтмол ариутгал хийх.	2 000.0	ХАБЭА	Бохир ус зайлуулах цэг тогтоох, Ерөнхий шаардлага MNS 6230-2010
Ахуйн хатуу хог хаягдлыг орон нутгаас заасан цэгт тээвэрлэн хүргэж, устгах.	Уурхайн дотоод зардал	Байгаль орчны мэргэжилтэн	Хог хаягдал хадгалах, цуглуулах, тээвэрлэх устах журам

Аюултай хог хаягдлыг ангилан хадгалах, тохирох аргын дагуу зайлуулах, устгах.	4 000.0	Худалдаа хангамжийн алба, Байгаль орчны мэргэжилтэн	Хог хаягдал хадгалах, цуглуулах, тээвэрлэх устгах журам
Бохирдолд өртсөн /Масло, түлш, гидрийн шингэн гэх мэт/ хөрсийг саармагжуулах.	5 000.0	ШТС, УНХ, АБХ, ЗХ, ТҮХ, Байгаль орчны мэргэжилтэн	Хог хаягдлын тухай хууль
Нийт	15 000.0		

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэн ажиллах
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг зөвлөмжийн дагуу боловсруулж, хэрэгжүүлэн тайлагнана. Хэрэв байгаль орчны холбогдох стандартад заасан хэмжээнээс илүү бохирдсон үзүүлэлт илэрсэн тохиолдолд бохирдлыг багасгах арга хэмжээг авах
 - Үйлдвэрлэлийн технологийн горим, заавар, аюулгүй ажиллагааны шаардлага, дүрэм, журам стандартыг ажиллагсдад эзэмшүүлэх мөн экологийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах
 - Байгаль орчинд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж, байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон ажиллах
 - Улсын болон орон нутагт төлөх татвар, төлбөр, хураамжийг төлж барагдуулах

№	Авах арга хэмжээ	Урьдчилсан Зардал мян.тө	Гарах үр дүн	Хэрэгжүүлэгч
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, энэ чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоох	-	Орон нутгийн иргэд болон ажилтанууд байгаль орчны тухай мэдээлэлээ дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдол, аливаа гэмтэл ослыг буурна.	Байгаль орчны мэргэжилтэн ХАБЭА
2	Орон нутгийн иргэд, хөрш уурхай, нутгийн удирдлагын саналыг тусгасан нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулж явуулах тайлагнах.	-		Байгаль орчны мэргэжилтэн
3	Байгаль орчныг хамгаалах болон аюулгүй ажиллагаатай холбогдсон сургалтыг жилд 1-2 удаа тогтмол хийж байх.	ХАБЭА-ын зардал тусгагдсан		Байгаль орчны мэргэжилтэн, ХНА, ХАБЭА
4	Сөрөг нөлөөллийг багасгах, дүйцүүлэн хамгаалах ажиллагааны төлөвлөлтийг урт хугацаагаар төлөвлөн, хэрэгжүүлэх арга зам, төсөвийн хөрөнгийг тодорхой гаргах.	-		Байгаль орчны мэргэжилтэн
5	Байгаль орчныг хамгаалах асуудлаар жилийн тайлангаа орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь гаргаж өгч байх.	-		Байгаль орчны мэргэжилтэн

6	Жил бүрийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөө БОЯ-аар хянуулан баталгаажуулах.	-	хохирлоос сэргийлэхэд чиглэсэн дүгнэлт, зөвлөмжтэй болно.	Байгаль орчны мэргэжилтэн
7	Болзошгүй осол аюулын үед орон нутгийн эмнэлгийн болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар тохиролцож гэрээ байгуулж ажиллах.	ХАБЭА-ын зардалд тусгагдсан	Учирч болзошгүй алдагдал, хохирлоос сэргийлнэ.	ХАБЭА
8	Ослын үед ажиллах ИТА, ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, сургалт явуулах.	ХАБЭА-ын зардалд тусгагдсан		Ерөнхий инженер, ХАБЭА
9	Байгаль орчны Аудитын үл тохиролын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах.	-		Байгаль орчны мэргэжилтэн

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ

“Шивээ-Овоо” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 7-р сарын тогтоолоор батлагдсан Байгаль орчны журмын 4.9-ийн 4.9.1, 4.9.2 -д заасны дагуу компанийн тухай хуулийн 83-р зүйлийн 83.1, Хөдөлмөрийн дотоод журмын 3-р зүйлийн 3.1 дэх заалт, Захирлын зөвлөлийн 2018 оны 8-р сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрээр А/83-ийн 1-р хавсралт тушаалаар батлагдсан “Агаарийн чанар болон тоосны хяналт шинжилгээ хийх заавар”-ын дагуу хийгдэнэ.

Агаарын чанарын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэх тохиолдолыг шалгах, хэмжилтийн мэдээний жилийн бичилт динамикийг гаргах зорилгоор агаар орчны тоосны агууламж, хүхрийн исэл, азотын исэл, тоосны хуримтлалыг хэмжинэ.

Уур амьсгалын хэмжилт

Хэмжих үзүүлэлт: Температур, харьцангуй чийгшил, даралт, салхины хурд, чиглэл, нарны цацраг, хур тунадас, цасны зузаан, ууршилт.

Давтамж: 24 цагийн турш 1 цагийн зайтай

Хэрэглэгдэх багаж: Цаг уурын автомат бичил станц.

Тоосонцорын хэмжилт

Аргачилал: Шууд хэмжилтийн 30 минутын дундаж.

Хэмжих үзүүлэлт: Тоосонцорын нийт хэмжээ /TSP/ болон том ширхэглэгт тоосонцор /PM 10/, нарийн ширхэгтэй тоосонцор /PM 2.5/

Стандарт: Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS 4585:2007)

Хэрэглэгдэх багаж: Аэрозолын шууд хэмжилтийн багаж /DustTrak DRX 8533/

Хэмжилтийн цэгүүд: Уурхайн хамгийн их тоосжилт үүсдэг цэгүүдийг сонгож авсан болно.

Агаарын бохирдолын хэмжилт

SO₂, NO₂ –ийн хэмжилтийг гадны лабораторитой хамтран хагас жилд 1-ээс доошгүй удаа гүйцэтгэнэ.

Тоосны тунац хэмжилт

Хэмжих үзүүлэлт: Сард 1 м² талбайд унах тоосны жин /гр/

Хэрэглэгдэх багаж: Тоос уналтыг хэмжих бортого

Хөндлөнгийн хяналтын хэмжилт

Давтамж: Жилд 1 удаа

Байршил: Уурхайн эдэлбэр газарт

Хэмжих үзүүлэлт: Агаарын тоосны хяналт (PM 2.5, PM 10, SO₂, NO₂)

Гүйцэтгэгч: Мэргэжлийн байгууллага

УСАН ОРЧНЫ ХЯНАЛТ

“Шивээ-Овоо” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 7-р сарын тогтоолоор батлагдсан Байгаль орчны журмын 4.9-ийн 4.9.5 -д заасны дагуу компанийн тухай хуулийн 83-р зүйлийн 83.1, Хөдөлмөрийн дотоод журмын 3-р зүйлийн 3.1 дэх заалт, Захирлын зөвлөлийн 2018 оны 8-р сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрээр А/83-ийн 2-р хавсралт тушаалаар батлагдсан “Усны дээж авах заавар”-ын дагуу хийгдэнэ.

Шивээ-Овоо ХК-ийн уурхайд нийт 12 хяналтын цооногоос 7 хоног тутамд хэмжилтийн мэдээллийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэн тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Гүний усны хэмжих үзүүлэлтүүд: Гүний усны хяналтын цооногуудад усны түвшний хэмжилтийг явуулахаас гадна, усны чанарын өөрчлөлтийг хянана.

ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН ХЯНАЛТ

“Шивээ-Овоо” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 7-р сарын тогтоолоор батлагдсан Байгаль орчны журмын 4.9-ийн 4.9.6 -д заасны дагуу компанийн тухай хуулийн 83-р зүйлийн 83.1, Хөдөлмөрийн дотоод журмын 3-р зүйлийн 3.1 дэх заалт, Захирлын зөвлөлийн 2018 оны 8-р сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрээр А/83-ийн 4-р хавсралт тушаалаар батлагдсан “Хөрсний дээж авах заавар”-ын дагуу хийгдэнэ.

Уурхай орчмын хяналтын цэгүүдээс дээж авч лабораторид шинжлүүлэх үзүүлэлтүүд:

- Хөрсний дасжилт, шүлтлэг
- Урвалын орчин
- Карбонат
- Ялзмаг
- NO₃
- Цахилгаан дамжуулалт
- Механик бүрэлдэхүүн

Хөрсний шинжилгээ хийх

1. Ургамал тоосжилтын нөлөөнд өртсөн байдлыг тодорхойлох.
2. Ургамлын үрийн ургалтын чадварыг өсгөвөрт ургуулан турших.
3. Усны химийн хэрэгцээт хүчилтөрөгчийн тодорхойлох.
4. Нөхөн сэргээлтийн туршилтын үр дүнг анатомийн түвшинд шинжлэх.

Стандартууд :

- MNS 1900:2010 - Ундны усны эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт
- MNS 4696:1998 - Нянгийн тоо
- MNS 4697:1998 - Гэдэсний савханцар
- MNS 6340:2003 – Салмонелла

- MNS 5668:2006 - Бохир усны микробиологийн шинжилгээний арга, Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян
- MNS 6148:2010 - Шүүрлийн усны стандарт
- MNS 6148:2010 - Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- MNS 4943:2011 - Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт №10

Хянах үзүүлэлт	Дээж авах цэгийн тоо	Дээж авах байршил	Давтамж	Төсөв (мян.төг)	Зөвшөөрөгдөх хэмжээ, баримтлах стандарт, аргазүй
Агаар					
Тоосжилт (нийт, PM10, PM2.5), Нүүрс-төрөгчийн дутуу исэл (CO), Хүхэрлэг хий (SO ₂), Азотын давхар исэл (NO ₂)	5	1. Хөрс хуулалтын орчин 2. Нүүрс гаргалтын орчин 3. Нүүрс ачилтын орчин 4. Уурын зуухны орчин 5. Шатахуун түгээгүүрийн орчин	Жилд 2 удаа	225.0	<ul style="list-style-type: none"> MNS 6063: 2010 Агаарын чанар хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 4585:2007 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага
Температур, шуугианы түвшин, доргион гэрэлтүүлэг, чийгшил тоосжилт (нийт, PM 10, PM2.5) Нүүрс- төрөгчийн дутуу исэл (CO) Хүхэрлэг хий (SO ₂) Азотын давхар исэл(NO ₂)	15	Ажлын байр	Жилд 2 удаа	675.0	<ul style="list-style-type: none"> MNS 4585: 2007 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 5002:2000 Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага

Хянах үзүүлэлт	Дээж авах цэгийн тоо	Дээж авах байршил	Давтамж	Төсөв (мян.төг)	Зөвшөөрөгдөх хэмжээ, баримтлах стандарт, аргазүй
Хөрс					
<p>Хөрсний үржил шимийн үзүүлэлт (рН, ялзмаг, карбонат, Ca^{2+}, Mg^{2+}, K_2O, P_2O_5) механик бүрэлдэхүүн, хүнд металлууд Cr, Pb, Cd, Ni, Zn</p>	10	<ol style="list-style-type: none"> 1. Гадаад овоолго 2. Мод тарьсан талбай 3. Засварын газар 4. Шатахуун түгээгүүр 5. Автомашины зогсоол 6. Хог хаягдлынцэг 7. Уурхайн болон Оффис, байрнуудын уурын зуух 8. Нөхөн сэргээлтийн талбайд 	Жилд 1 удаа	800.0	<ul style="list-style-type: none"> • MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ • MNS 3310:91 Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох • MNS 3298:1990 Хөрсний шинжилгээний дээж авах ерөнхий шаардлага • MNS 3307:91 Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга • MNS ISO 10390 Хөрсний чанар.рН тодорхойлох • MNS 4006:1988 Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох • MNS 2143:2000 Хөрсний физик шинж чанарыг тодорхойлох арга

Хянах үзүүлэлт	Дээж авах цэгийн тоо	Дээж авах байршил	Давтамж	Төсөв (мян.төг)	Зөвшөөрөгдөх хэмжээ, баримтлах стандарт, аргазүй
Усан орчин					
<p>Ундны усны ерөнхий химийн шинжилгээ (pH, Ca²⁺, Mg²⁺, NH₄⁺, Na⁺, K⁺, Fe³⁺, SO₄²⁻, HCO₃⁻, Cl⁻, NO₂⁻, NO₃⁻) Хүнд металлууд Cr, Pb, Cd, Ni, Zn Бактерлиогийн шинжилгээ(нийт нянгийн тоо, гэдэсний бүлгийн нян, халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян <i>Escherichia. Coli</i>, Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян /Salmonella, Shigella/, Сульфид задлагч агааргүйтэн /Clostridium. Perfringens/</p>	8	<ol style="list-style-type: none"> 1. Уулын ажилчдын цайны газар 2. Хаялгын турба 3. 21-р худаг 4. Хаялгын нуур 5. Ус цэвэршүүлэх төхөөрөмж 6. УШ-ийн хяналтын цооног 7. Уурхайн болон Оффис, байрнуудын уурын зуух 8. Бохирын ус 	Жилд 2 удаа	1 300.0	<ul style="list-style-type: none"> • MNS 900: 2005 Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ • MNS 6148:2010 Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт • MNS 4943:2008 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага □ MNS ISO 10523-2:2003 pH тодорхойлох • MNS ISO 4889-99 Цахилгаан дамжуулах чанар тодорхойлох • MNS ISO 6059:2005 Хатуулаг тодорхойлох • MNS ISO 2572-99 Кальци тодорхойлох • MNS ISO 9297:2005 Хлорид тодорхойлох

Хянах үзүүлэлт	Дээж авах цэгийн тоо	Дээж авах байршил	Давтамж	Төсөв (мян.төг)	Зөвшөөрөгдөх хэмжээ, баримтлах стандарт, аргазүй
Бактерлиогийн шинжилгээ (нийт нянгийн тоо, гэдэсний бүлгийн нян, халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян,) <i>Escherichia. Col</i> , Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян / <i>Salmonella</i> , <i>Shigella</i> /, Сульфид задлагч агааргүйтэн / <i>Clostridium. Perfringens</i> /	4	1. Уулын цайны газар 2. Орон сууц 3. Хаялага нуур 4. Лаборатори	Жилд 2 удаа	200.0	<ul style="list-style-type: none"> • MNS 4425:97 Гидро карбонат тодорхойлох • MNS ISO 7890:2001 Нитрат тодорхойлох • MNS 4431-2005 Нитрит тодорхойлох • MNS 4428-97 Аммони тодорхойлох <input type="checkbox"/> MNS 4430:2005 Төмөр тодорхойлох
Ургамал					
Ургамлын төрөл зүйл, бүрхэц, түүний хомсдолт, доройтлын зэрэглэл, бодгалийн тоо, дундаж өндөр, биомасс	2	Үйлдвэрлэлийн бүсийн ашиглалтанд өртөөгүй талбай Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай	Жил бүр	БОННУ-ий зардалд тусгагдсан	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> MNS ISO 11269-1:2002, MNSISO 11269-2:2002 Хөрсний чанар.Хөрсний ургамлын бохирдолтын нөлөөллийг тодорхойлох. 1, 2-рхэсэг • MNS 5546:2005 Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхагдлыг тогтоох ерөнхий шаардлага.
Амьтан					
Амьтны төрөл, зүйлийн бүрэлдэхүүн тоо толгой тархалт, байршил	1	Төслийн талбайн нөлөөллийн бүс	Жил бүр	БОННУ-ий зардалд тусгагдсан	Амьтан судлалын нийтлэг арга зүйг хэрэглэнэ.
Нийт дүн 3 200.0 мян.төг					

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оршин суугч, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ Хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Төсөв мян.төг
Багийн ИТХ	ИТХ-д илтгэл тавьж, мэдээлэл өгөх	Тухайн жилийн БОМТ-ий биелэлт гүйцэтгэл	Жилд 1 удаа	100.0
Засаг даргын Тамгын газар	Төслийн байгаль хамгааллын ажлын талаар мэдээлэл өгөх			100.0
Нөлөөлөлд өртөгч оршин суугчид	Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар мэдээлэх			100.0
Нийт	300.0 мян.төг			

БАТЛАВ:

“ШИВЭЭ-ОВОО” ХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.ЭНХТҮВШИН

Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөөний Төсөв зардал

№	Зардлын утга	Нийт зардал мян.төг	Тайлбар
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал		Уурхайн зардалд тусгагдсан
2	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлын зардал		Уурхайн зардалд тусгагдсан
3	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлын зардал		Уурхайн зардалд тусгагдсан
4	Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	15 000.0	
5	Биологийн нөхөн сэргээлт /5га талбайд/	15 000.0	
6	Уурхайн захиргаа, бусад барилга байгууламж бүхий талбайд мод тарих зүлэгжүүлэх, тохижуулах.	15 000.0	
7	Шүүрүүлэхийн усны хаялбарын шуудууг бетондох, нөхөн сэргээх зардал /2 га талбай/	37 800.0	Хөрөнгө оруулалтын зардалд
8	30-н жилийн ойд зориулан Орон нутагтаа Ногоон Байгууламж Цэцэрлэгт хүрээлэн бий болгох зардал	30 000.0	Хөрөнгө оруулалтын зардалд
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	3 200.0	

№	Зардлын утга	Нийт зардал мян.төг	Тайлбар
10	2018 онд ТЭЗҮ батлагдаж байгаа тул БОНБНҮ-ний тайлан хийх зардал	45 000.0	Хөрөнгө оруулалтын зардалд
11	Байгаль орчны Аудит хийлгэх зардал	20 000.0	Хөрөнгө оруулалтын зардалд
12	БОМТ-ын хэрэгжилтийг тайлагнах зардал	300.0	
13	Усалгаа, арчилгаа, тордолт хийлгэх 4 гэрээт ажилтан ажилд авч ажиллууулах зардал	16 800.0	
	Нийт дүн	198 100.0	
	Үүнээс: Уурхайн зардлын дүн	132 800.0	
	БОМТ-ний зардлын дүн	65 300.0	

Төсөвтэй танилцсан: Санхүү хариуцсан ТДЗахирал

Э. Цасчихэр

Төсөвтэй танилцсан: Ерөнхий инженер

Г. Гэрэлхүү

Төсөв хянасан: Технологи бодлогын хэлтсийн дарга

П. Цэндпүрэв

Төсөв гаргасан: Байгаль орчны мэргэжилтэн

О. Бямбадорж